

Булган аймагт хэрэгжиж байгаа улс, орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын мэдээлэл

2022.11.10

Булган сум

Хутаг-Өндөр үерийн далан

Үерийн хамгаалалтын байгууламж С-3, С-4 / Булган аймаг, Хутаг-Өндөр сум/

Гүйцэтгэгч: “Хангилцаг” ХХК, түншлэгч “Эм Даблю Ти” ХХК

Зохиогч: “Гидро сооружение” ХХК,

Нийт төсөвт өртөг: 4,279,566,403 төгрөг

Ажлын явц: Тус ажлын хүрээнд С-3 суваг 1112 м С-4 суваг 755 м, нийт 1867 м суваг хийхээс 2022 онд 1112 м сувгийг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд тухайн онд 800,000,000 төгрөгийн санхүүжилт олгогдсон. Тус ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан. Гүйцэтгэл-40%-тай.



Хутаг-Өндөр сумын сургуулийн биеийн тамирын талбайн ажил

Гүйцэтгэгч: “Нано бриллиант констракшн” ХХК

Нийт төсөвт өртөг: 194,551,844 төгрөг

Ажлын явц: Тус ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа бөгөөд, тус ажлын хүрээнд хиймэл зүлэг бүхий хөлбөмбөгийн талбай, 4 м өндөр торон хашаа, 3 эгнээ 100 метрийн урттай гүйлтийн бетон замын ажлыг гүйцэтгэж 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байнгын ашиглалтад оруулсан.



Баян-Агт сумын ариутгах татуургын шугам, цэвэрлэх байгууламж

Гүйцэтгэгч: “Эрин гүрэн” ХХК

Зохиогч: “Их мянган инженерчлэл” ХХК

Нийт төсөвт өртөг: 395.523.157 төгрөг

Баян-Агт суманд 2021-2022 оны орон нутгийн байгаль хамгаалах сангийн төсвийн хөрөнгө оруулалтаас 400 сая төгрөгөөр сумын төвийг төвлөрсөн ариутгах татуургын системд холбох ажлыг “Эрин гүрэн” ХХК гүйцэтгэж 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байнгын ашиглалтад хүлээлгэж өглөө.




Тус ажлын хүрээнд нийт 940 м ариутгах татуургын шугам, 32 ш бохир ус татан зайлуулах худаг, хоногт 35 м³ ахуйн бохир ус цэвэрлэх септик байгууламжийн ажлыг гүйцэтгэсэн.

Хэрэглээний халуун ус

Ажлын нэр: Булган сумын айл өрх, албан газруудыг ээлж дараатайгаар хэрэглээний халуун усны шугамд холбох

Гүйцэтгэгч: “Сувдан элс” ХХК

Зохиогч: “Онолт од” ХХК



Тус ажлын хүрээнд 14, 15, 22, 23 дугаар нийтийн орон сууцны гадна, дотор шугам, 12 дугаар байрны гадна хэрэглээний халуун усны шугамын ажил хийгдэхээр зураг төсөвт тусгагдсан. Тус ажлыг 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байнгын ашиглалтад хүлээлгэж өгсөн. Ингэснээр нийт 300 хүүхдийн цэцэрлэг, нийтийн орон сууцны 147 өрхийг 2022 онд хэрэглээний халуун усны шугамд шинээр холбоод байна.

Бугат сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга

Гүйцэтгэгч: “Зост трейд” ХХК

Зохиогч: “Бес онцгой дизайн” ХХК,

Нийт төсөвт өртөг: 1.462.170.426 төгрөг

Ажлын явц: Барилга угсралын ажил 2021 онд суурийн ажил гүйцэтгэж 359.300.215 төгрөгийн санхүүжил авсан. Энэ онд 700.000.000 төгрөг тусгагдсан бөгөөд барилгын каркас дуусаж гадна ханны дүүргэлтийн ажил 70%-тай гүйцэтгэж байна. Соёлын төвийн барилга 2023.08.25-ны өдөр ашиглалтад орох бөгөөд нийт ажлын гүйцэтгэл 60%-тай явагдаж байна.



Булган аймгийн Хишиг-өндөр сумын хүүхдийн тоглоомын Талбайн тохижилтын ажил

Гүйцэтгэгч: “Нано бриллант констракшн” ХХК

Зохиогч: “Оргил цамхаг констракшн” ХХК,

Нийт төсөвт өртөг: 247,505,068 төгрөг

Ажлын явц: Булган аймгийн Хишиг-Өндөр сумын хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил нь 2021.10.01 - 2022.09.01-ны өдөр хүртэл он дамнасан ажил бөгөөд 2021 онд 164.000.000 гүйцэтгэл авсан. Гадна хашаа, явган зам, 300 ширхэг хайлаас сөөг, Сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоом бусад тоноглол суурилуулах ажиллууд нийт 5000м² тохижилтын ажил гүйцэтгэсэн. 2022.09.21-ны өдөр байнгын ашиглалтад хүлээж авсан.



Булган аймгийн сайхан сумын хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил

Гүйцэтгэгч: “ЭПО” ХХК

Зохиогч: “Оргил цамхаг консракшн” ХХК,

Нийт төсөвт өртөг: 233,568,244 төгрөг

Ажлын явц: Булган аймгийн Хишиг-Өндөр сумын хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил нь 2021.10.01 - 2022.08.01-ны өдөр хүртэл он дамнасан ажил бөгөөд Гадна хашаа, явган зам, 300 ширхэг хайлаас сөөг, Сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоом бусад тоноглол суурилуулах ажиллууд нийт 5000м² тохижилтын ажил гүйцэтгэсэн. 2022.11.09-ны өдөр байнгын ашиглалтад үүрэг даалгаварын биелэлтээр хүлээж авсан.



АЗДТГ-ЫН ХБТХОХ